

Научная статья
УДК 811.512.31
DOI 10.18101/3033-1310-2026-1-26-35

Монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэл судлалд буриад хэл, аялгууны үнэ цэн

© Гэрэлт-Од Батзаяа

доктор (Sc.D), дэд профессор,
Монгол улсын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн
Монгол улс, 13375, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Жуковын өргөн чөлөө, 54а
batzaya.g@mas.ac.mn

Хураангуй: Өдгөө ОХУ-д 661 000 орчим¹, МУ-д 101 980 орчим (Дөш, 2025: 107-108), БНХАУ-д 70000 гаруй (Сэнгэ нар, 2018: 1), — нийт 833 000 орчим буриад хэл, аялгуутан хүмүүс байна. ОХУ дахь буриадуудын ярьдаг нь бие даасан хэл болон хөгжсөн бол МУ-ынх нь монгол хэлний, БНХАУ-ынх нь өмнөд монгол хэлний аялгуу юм. Буриад хэл, аялгууны тухай нарийвчлан шинжилж үзвэл: нэг талаас, монгол хэлний язгуур шинжийг өнөө хүртэл хадгалан авч үлдсэн баримт цөөн бус байна; нөгөө талаас, монгол хэлний хөгжил хувьслын чиг хандлагыг тодорхойлохуйц хөгжсөн элементүүд ч байна. Ийнхүү буриад хэл, аялгуу нь хэл шинжлэлийн үүднээс монгол хэлний үнэ цэнтэй нэгэн чухал хэсэг болох нь тодорхой харагдана. Бид энэ өгүүлэлдээ буриадын утга зохиолын хэлний жишээ баримтыг буриад хэлний зөв бичих дүрмээр, монгол хэлний буриад аялгууны баримтыг монгол хэлний зөв бичих дүрмээр бичиж, онцолсон үгийн дуудлагыг IPA (International Phonetic Alphabet) — олон улсын авианы галигаар² тэмдэглэв. Харин өвөг, эртний, дунд үеийн монгол хэлний баримттай цуваа цагт харьцуулсан хэсэгт бичгийн галигаар³ бичлээ. **Түлхүүр үг:** буриад хэл, аялгуу, эртний шинж, хөгжлийн чиг хандлага, үнэ цэн.

Для цитирования

Гэрэлт-Од Батзаяа. Монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэл судлалд буриад хэл, аялгууны үнэ цэн // Бурятский язык и литература в школе. 2026. Вып. 1. С. 26–35.

Нэг. Монгол хэлний харьцангуй эртний шинжийг хадгалж үлдсэн нь:

1.1. Авиа зүйн түвшинд

Өвөг монгол хэлэнд а, ɛ, о, е, i, ө, и хэмээх хүчдэлийнхээ хувьд эсрэгцсэн эр чанга 4, эм сул 4 нийт 8 эгшиг байснаа “Хэлний хойгуур, хүчдэлтэй, эр чанга хэлэгдэж байсан i эгшгийн хүчдэл нь эртний монгол хэлний үе буюу барагцаалбал өвөг монгол хэлний сүүл үеэс XI-XII зууны үед аажим суларсаар үүргээ бүрмөсөн алдаж, хэлний урдуурх, хүчдэлгүй эм i-тэй адил байранд хэлэгдэх болж, долоон богино эгшигтэй болсон” [17, с. 219]. Энэ хувьсал монгол хэлний халх аялгуунд болсон бол бусад олон хэл, аялгуунд эр чанга i эгшиг одоо ч бий. Тухайлбал, буриад хэлэнд [ɪaŋ] — *инаг*, [ɪɪa:] — *илгаа*, [ɪzɪaŋ] — *инзаган*, [χaŋ:] — *харгы*, [oŋ:] — *ургы* гэх мэтээр хэлж, бичдэг бол монгол хэлний буриад аялгуунд [ɪaŋ] — *янаг*, [ɪzɪaŋ] — *янзага*, [ɪɪaltʰa] — *ялалт*, [ɪɪa:


¹ mn.wikipedia.org/wiki/Бүгд_Найрамдах_Буриад_Улс.

² []-д ердийн форматаар.

³ хаалтгүйгээр налуу (italic) форматаар.

Гэрэлт-Од Батзаяа. Монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэл судлалд буриад хэл, аялгууны үнэ цэн

цүи] — ялгаагүй, [dov:lɑŋ] — дугуйлан, [χaraŋχi:] — харанхуй, [oɣvi:] — яргуй гэх мэтээр хэлдэг. инзаган [inzɑvɑŋ] (nɑvɑŋ) — янзаган насан¹ гэдэг үгийн туршилт авиа зүйн зураг дээр [i] эгшиг нь халх аялгууны [i] эгшгээс амны нээлт арай агуу, хэлний арай хойгуур байранд бүтэж байгаа нь харагдана:



1.2. Хэл зүйн түвшинд

Буриад хэл, аялгуунд буй, өвөг язгуураа хадгалж үлдсэн үгс тухайн үгийн гарлыг хэлж өгдөг. Жишээ нь: Мо. *mölsün* > буриад. [mulihəŋ], халх. [møs] — мөс. Энэ нь мөл- язгууртай, мөлгөр, мөлийх зэрэг үгтэй төрөл үг юм. Халх зэрэг аялгууны “мөс” гэсэн язгуураас энэ үгийн гарал олдохгүй. Харин буриад, хэл, аялгуунд [l] гийгүүлэгчээ гээгээгүй байна.

Мо. *tenjüekü* > буриад. [tʰənʒe:xe], халх. [tʰeʃe:x] — тэжээх. Энэ нь тэн-язгууртай, хүний тэнд (зэрэгт) хүргэх гэсэн утгатай тэн+ж+ээ+х гэсэн бүтэцтэй үг. Халх аялгууны “тэжээх” гэдэг хэлбэрээс энэ үгийн гарал олдохгүй. Харин буриад, хэл, аялгуунд [n] гийгүүлэгчээ гээгээгүй байна.


Мо. *talqa-* > буриад. [tʰalχɑŋ], халх. [qʏrəʃ] — гурил. Энэ нь талхалж нунтагласан буудай буюу талх- язгууртай үг. Гэтэл халх зэрэг аялгуунд “гурил” гэдэг үг бий болж, харин “талх” гэдэг үгийн утга шилжиж, гурилаар хийсэн бэлэн бүтээгдэхүүнийг заадаг болсон. Тэрхүү бөөрөнхий хэлбэртэй бэлэн бүтээгдэхүүнийг нэрлэсэн үгийн уг язгуур нь “талхалж нунтагласан юм” гэж ойлгогдохгүй. Харин буриад хэл, аялгуунд анхны утгаараа байгаа тул үгийн гарал нь ойлгомжтой байна.

Хамааны тийн ялгалын нөхцөл **in/*an* гэсэн гуравдугаар биеийн төлөөний үгээс үүсэлтэй [4, с. 42-44], [18, с. 30-40]. Орчин цагийн монгол хэлний халх аялгуу, мөн дагуур, дуншаанаас бусад бүх төрөл хэл, аялгуунд уг тийн ялгалын нөхцөл [i/a] хэмээх хоёр эгшигт хувилбартай байдаг. Дунд үеийн монгол хэлэнд *i/a* эгшгээр ганц, олны ялгаа заахаа больсны дараа *-in* хувилбар нь өмнөө жийрэглэх *j* гийгүүлэгч авч *-jin* болсон бол *-an* хувилбарын үүрэггүй болсон *a* эгшиг нь гээгдэж, *n* гийгүүлэгч дангаар үлдээд, өмнө нь холбох эгшиг орсны дүнд *-un/-ün* хэлбэр үүссэн байна. Ингэж монгол бичгийн хэлэнд *-jin*, *-un/-ün* хоёр хэлбэр бүрэлдэн тогтжээ. Харин монгол хэлний буриад, ойрад аялгуу, буриад, өмнөд монгол, монгор, зүүн ёгур хэлэнд анхны *i/a* хоёр эгшигт хувилбарыг өнөө хүртэл тээж иржээ. Жишээ нь, буриад хэлэнд: Хүхэрэн манархан Нарһата уулануудай [o:lano:dæ:] оройһоо наранай [naranæ:] һугаран дэгдэхэдэ, мүнгэн сагаан шүүдэр гансата хатажа, һуниндөө үндэр хаяагай [χajavæ:] узуураар хорон хэвтэһэн жэргэмэлнүүд һуриша мэтээр харбагдан дэгдэжэ, хонгёо аялгая

¹ Дорнод аймгийн Баяндун сумын уугуул, ага буриад Лувсаны Оюунцэцэгийн авиалснаар.

сасан, *тэнгэрэй* [tʰəŋgərei] *майханийе дорьбоон шэнхинүүлжэ байхадал гэнэ.* /Х.Намсараев/ гэх мэтээр *-ай/-эй/-ой* [-æ:/-ei/-œ:] хэлбэр байна.

Гарлын тийн ялгалын нөхцөлийн анхны хэлбэр нь *-ца/-це* байсан [10, т.116], [21, т.200] бөгөөд орших *-а* нөхцөлтэй нэгдэж *-аца/-еце* болсон [9, т. 33], [10, т.33] байна. Алтайн олон хэлэнд гарах тийн ялгалын нөхцөл нь өгөх орших тийн ялгалын суурин дээр бүтэж бүрэлдсэн байдаг бөгөөд анхдагч хэлбэр *-ца* нь *-da/-ta>-ца>-sa* хэмээн гийгүүлэгч сулран хувьссанаас бий болжээ. Өөрөөр хэлбэл өгөх орших, гарахын тийн ялгал эхлээд нэг байгаад, хөгжлийн явцад хоёр салахдаа *-da/-ta* хэвээр үлдсэн нь өгөх орших утга, суларч хувьссан нь гарах утга илтгэх болжээ. Гэвч энэ хоёр хэлбэр шууд тодорхой заагтайгаар салж хоёр тийн ялгал болчихсонгүй, хэсэг хугацаанд хутгалдан холилдож явсаар, *-ца* хэлбэр нь монгол хэлний эрт болон дунд үед дахин өгөх оршихын *-а* болон *-da/-ta*-тай нийлж *-аца*, *-даца/-таца* хэмээх шинэ хэлбэрийг үүсгэсний дараа сая хоёр өөр тийн ялгалын зааг ялгаа тодрон хөгжсөн (Хасбаатар) ажээ. Үүнээс монгол бичгийн хэлэнд *-аца/-еце* хэмээх хэлбэр нь үлдэж, орчин цагийн монгол хэлнүүдэд гурван өөр замаар хувьсан хөгжсөн байна. Үүнд: 1. Халимаг хэлэнд VCV¹ хэмээх бүтцээ хадгалсан. 2. Монгол хэлний халх, ойрад аялгуу, өмнөд монгол хэлний олонх аялгуу, дагуур хэлэнд эцсийн эгшгээ гээсэн. 3. Монгол, зүүн ёгур, бао-ань, дуншаан хэлнүүдэд анхны CV бүтцээ хадгалсан бол буриад хэл, аялгуунд ч бас хадгалахдаа гийгүүлэгч нь суларч *-haa/-hээ/-hoo/-hөө* [-ha:/-he:/-hœ:/-hø:] болжээ. Үүнийг загварчлан үзүүлбэл²:



Жишээ нь: *Баашха үбгэн хуурмагша, шанар муутай юумэ дархалха ой ухаанһаа* [oɣa:ŋha] *дурагуй, шадаал хаа мүнхэ байха юумэ бүтээхэ гэжэ үнэн зүрхэнһөө* [zurxəŋhø:] *хүсэдэг.* /Х.Намсараев/.

Болзооны нөхцөл үйлийн *-basu/-besü* нөхцөл *ba* (өнгөрсөн цаг) + *su* (асуух утгатай) гэдэг хоёр хэсгээс бүрдсэн [1, т. 20] бөгөөд XVII зуунд *-sa/-se* нөхцөл дангаараа байсныг (*шүрүқи болуса та кейү сойурqабai /altan tobci/*) “Монгол үгсийн язгуурын толь”-д тэмдэглэсэн [16, т. 2917] байдаг. Тэгвэл орчин цагт зүүн ёгур, монгол, дуншаан, бао-ань, өмнөд монгол хэлнүүдэд уг *-sa/-se* хэлбэр уламжилж, өмнөд монгол хэлний барга-буриад аялгуунд гийгүүлэгч нь суларч -

¹ V-vowel (эгшиг), C-consonant (гийгүүлэгч).

² ӨМХ — Өвөг монгол хэл, ЭМХ — Эртний монгол хэл, ДМХ — Дунд үеийн монгол хэл, ОЦМХ — Орчин цагийн монгол хэл, Мо — Монгол бичиг.

haa/-hээ [-ha:/-hэ:] болсон байна. Жишээ нь: *Үүлэн хөөрэхээ* [хө:гэхэ:] *бороо болохо, үгэ хөөрэхээ* [хө:гэхэ:] *хэрүүл болохо. /Онтохон үгэ/*.

Нэгдүгээр биед зорин хандах төлөвийн *-suγai/-sügei* нөхцөл *su(асуух)+γa(үйлдүүлэх)+i(онцлох)* хэмээх бүтэцтэй [12, т. 118–119], [3, т. 138]. “Эртний монгол хэлэнд нэгдүгээр биеийн ганц тоог *su/-sü* нөхцөлөөр, хэлэлцэгчийг эс багтаасан олон тоог *-suγae/-sügei* нөхцөлөөр илтгэж байсан бөгөөд... хэрэглэгдэх хүрээ хэмжээ нь цөөрч *-suγae/-sügei* нь багтаах, эс багтаах ялгаагүй болж, *-su/-sü* нь *-γa*-д орлогджээ” [16, т. 2898–2899]. Орчин цагт уг ганц тооны утгатай нөхцөл халимаг хэл, монгол, өмнөд монгол хэлний суурь аялгуунд байхгүй болсон бол ойрад аялгуунд *-су/-сү* [-so/-sy] хэлбэрээрээ уламжилж, буриад хэл, аялгуунд шүргэх гийгүүлэгч нь суларсан *-һуу/-һүү* [-ho:/-hu:] хэлбэртэй болсон. Жишээ нь: *Ушар удхыень тобишохоноор хэлэхүүб* [хэлэху:β]. *Шагнаад һуугты, ойлгуулһүүб* [сө:лво:лхо:β]. *Бишыхан аад, ехэ һонин хуушанай үльгэр бий юумэ, дуратай хаатнай хөөрэжэ үгэхүүб даа* [уүэху:βда:]. */Х.Намсараев/*. Мөн зүүн ёгур хэлэнд [-sa/-se/-sə/-so/-su] хэлбэр идэвхтэй, монгол хэлэнд [-so/-son] хэлбэр ховор хэрэглэгддэг.

Хүсэн хандах төлөвийн *-γasai/-gesei* нөхцөл *γa+suγai(su+γai)* гэж дам үүссэн [14, т.62-63] нөхцөл юм. Орчин цагт монгол хэлний суурь, өмнөд монголын баримжаа аялгуунаас бусад олон монгол хэл, аялгуунд эл нөхцөлийн эхний үе байхгүй. Үүнд: монгол хэлний ойрад аялгуу болон халимаг хэлэнд [-sæ:], монгол, бао-ань хэлэнд [-sa/-se] хэлбэртэй бол буриад хэл, аялгуунд *-һай/-һэй/-һой* [-hæ:/-hei/-hœ:] хэлбэртэй байдаг нь энэхүү нийлмэл бүтээвэр бүрэлдэн тогтохын өмнөх хэлбэр байна. Жишээ нь: *Сэсэншье, хүсэтэйшье, зоригтойшье тэрэ хүнийе хараһайб, тэрэ хүндэ зорюута ошоһойб* [э]hœ:β] гэжэ *Доржо һанана. Хубүүнийнь нютагтаа хүдэлдэг болошоһой* [bəl]hœ:] даа. */Ч.Цыдендамбаев/*.

Буриад хэл, аялгууны уриалан хандах төлөвийн *-gtий* [-xt^hi:] нөхцөл монгол бичгийн *-γtun/-gtiin* хэлбэрээс гаралтай. Сонгодог монгол бичгийн үеэс хойших хувьслыг авч үзвэл *q>γ* гийгүүлэгч нь монгол хэл, өмнөд монгол хэл, буриад хэл, аялгуунд суларсан бол халимаг хэл, ойрад аялгуунд сугарч, буриад, халимаг, ойрадад эгшиг нь бас уруулын шинжээ алдсан байдаг. Үүнээс буриад хэл, аялгуунд [-xt^hi:] гэсэн хэлбэртэй. Жишээ нь: *Дээшээ гаража һуугтуй* [ho:xt^hi:]. *Нима Гармаев, Тархяа хөөдэ, юрэдөө, энэ албан тушаалһаа намайе сүлөөлэгтуй* [sulə:ləxt^hi:]. */Н.Балдано/*. “Энэ нөхцөл нь олон тооны *-d*, үйлт нэрийн ирээдүй цагийн *-qi*, *-qi-n*, *-qi-i* хоёроос бүтсэн бөгөөд *d,q>g* хоёр гийгүүлэгч нь тонгорч, *-gtun*, *-gtui* болсон” [2, т.351] байна. Харин эрдэмтэн М.Саруул-Эрдэнэ “*d* нь үйлдэгдэх хэвийн нөхцөлөөс гаралтай бол *qin* нь тодотгон холбохын олон тоот хэлбэр болно. Үүнтэй эсрэгцэх ганц тоот хэлбэр нь *qui* бөгөөд *dqui* гэсэн ганц тоот хүндэтгэн захирах нөхцөл мөн байсныг орчин цагийн буриадын [-xt^hi:] нөхцөл гэрчилж байна” [14, т. 61] гэсэн байна. Аль нь ч гэсэн буриад хэл, аялгууны хэлбэр энэ нөхцөлийн гарал, бүтцийг илтгэхэд тусалдаг.

1.3. Үгийн сангийн түвшинд

Өвөг монгол хэлэнд нэгдүгээр биеийн төлөөний үг **mi-*, **ma-* язгууртай байжээ. Буриад хэл, аялгуунд нэгдүгээр биеийн төлөөний үг олон тоонд [bidə/bidənə] — *бид/бид нар*, [man] — *ман* гэсэн үгс байгаа нь өвөг ба сүүлийн үеийн хэлбэр хоёул уламжлагдсан байна.

Буриадууд хүүхдийг [хэне: хе:лэнт^hiw] — *-Хэний хээлэнтив?* гэж асуудаг нь - *Хэний хүүхэд вэ?* гэсэн үг. *kegeli* > [хе:л] гэдэг үг эртний болон дунд үеийн монгол хэлэнд *'Хээл нэгтэй, хэлхээ бэхтэй [хүмүүс]'* (МНТ) гэх мэтээр өргөн утгатай байсан бол орчин цагийн монгол хэлний халх аялгуунд зөвхөн мал, амьтны хээлийг заах болж, хүний тухайд хэрэглэхээ больж, утга нь явцуурчээ. Харин буриад аялгуунд энэ үгийн утга хэвээр байна.

Мөн [olɣaŋ] — *улхан (довцог)*, [saɣaŋ] — *гаһар (гань, ганц)*, [gulmurə] — *гүлмүр (гэнэн)*, [burxirxə-] — *бүрхирхэ (/буга/ урамдах)*, [ʃuləyən] — *шүлгэн (шүдлэн)*, [χənzə:hən] — *хонзоон (хошиного)*, [uləxə] — *үлэхэ (хөмхий)*, [moχaŋjo:lχa] — *мухарюулха (өнхрүүлэх)*, [t^hoβa:r] — *тугаар (сая)*, [mina:] — *минаа (ташуур)*, [t^he:li] — *тээли (тиймээ, уухай)*, [ɔnt^həhən] — *онтоон (оньсого)* гэх мэт олон үг “Монголын нууц товчоо”-нд байдаг хэлбэрээрээ буриад хэл, аялгуунд одоо ч бий [7].

Хоёр. Монгол хэлний хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохуйц хөгжсөн нь:

“Аливаа үйл бүхэлдээ хүч зардал бага гаргаж богино хугацаанд амар хялбар хийх гэж эрмэлздэг шигээ хүн амьд сэрүүн байх бүх хугацаандаа хэлний материал (авиа, бүтээвэр, үг гэх мэт)-ыг хэрэглэн сэтгэн бодож, санасан бодсоноо илэрхийлэн өөр хоорондоо харилцахдаа хэлний төсөр дөхөм бага материалаар бага хугацаанд их хүч гаргалгүй санаагаа илэрхийлж харилцах эрмэлзэл аяндаа бий болдог. Тэр нь яваандаа хэл бүрийн хөгжлийн гол эрмэлзэл, зүй тогтол болжээ. Үүнийг хэл шинжлэлд хэлний хэмнэл буюу хүчдэл хэмнэл гэдэг. Хэл бүрийн хөгжлийн нэгэн чухал зүй тогтол болсон хэлний хэмнэх эрмэлзэл дэлхий дахины олон хэлэнд заримд нь сайн, заримд нь тааруу дулим, янз бүр хэрэгждэг байна” [5, т. 323]. Энэхүү зарчим ёсоор авч үзвэл, бусад монгол хэл, аялгуунаас түрүүлэн хөгжсөн авиалбар, бүтээврүүд орчин цагийн буриад хэл, аялгуунд байна.

2.1. Авиа зүйн түвшинд

Гийгүүлэгч авианы сулрал буриад хэл, аялгуунд системтэй байдаг. Эртний болон дунд үеийн монгол хэлний *č* гийгүүлэгч орчин цагийн буриад хэл, аялгуунд [ʃ], [s] болсон, *ʃ* гийгүүлэгч [z], [z] болсон, *s* гийгүүлэгч [h] болсон, *q/k* гийгүүлэгч [h] болсон байна. Жишээ нь:

Мо. *činar* > буриад. [ʃanaŋ]

Мо. *časun* > буриад. [sahaŋ]

Мо. *eʃi* > буриад. [eʃi:]

Мо. *ʃasaburi* > буриад. [zahaβaŋ]

Мо. *büse* > буриад. [behe]

Мо. *ʃiyaqan* > буриад. [za:haŋ]


Мо. *kogürge* > буриад. [hu:reg] гэх мэт.

Эдгээр нь бүгд дээр өгүүлсэн хэлний хэмнэлтийн жишээ болох юм. Буриад хэл, аялгуунд гийгүүлэгч авиа ийнхүү сулран хувьссан явдлыг эрдэмтэн Т.Цэрмаа “Ийм хөөмийн шүргэх h гийгүүлэгч эртний монгол хэлний үгийн эхэнд байсан бөгөөд авианы сулралын хуулиар монгол хэлний хөгжлийн дунд үе буюу XV зууны үед гээгдэж, үгүй болсон билээ. Харин сийгэх авианаас үүсэлтэй хөөмийн сул шүргэх h авиа нь буриад аялгуунд бүр хожим тухайлбал, эрдэмтэн Б.Я.Владимирцовын ажиглан тэмдэглэснээр сонгодог монгол бичгийн хэлний үе буюу XVI зууны эцэс, XVII зууны эхнээс авианы сулралын хуулиар үүсэж, шинэ үед тодорхой нэг аялгуунд өөр авианаас сэргэн хөгжсөн байна... Энэ нь буриад

аялгууны дотоод хөгжлийн тогтолцоотой үзэгдэл юм” [20, т. 83] хэмээн дүгнэжээ. Ийнхүү, буриад хэл, аялгуунд эгшиг авиа төдийлөн суларч балархайшаагүй бол гийгүүлэгч авиа ихээхэн суларсан нь хэлний хэмнэлтийн зарчим, чухамдаа хэлний хөгжлийн чухал хандлагыг илэрхийлдэг байна. Эрдэмтэн Ж.Санжаа “Хэл тасралтгүй боловсрон хөгжихийн нэг тал нь авиаг хэлэхэд өгүүлэх эрхтний хүчдэлийг хэмнэх зарчим юм. Хэлний хэмнэлтийн нэг нь авиа сулрах ёс бөгөөд өнөөгийн монгол хэлний чухал нэг хандлага болсон” [13, т. 123] гэжээ.

2.2. Хэл зүйн түвшинд

Бие заах нөхцөл орчин цагийн монгол, өмнөд монгол хэлэнд байхгүй. Монгол хэлний ойрад, буриад, дархад аялгуу, халимаг, буриад, дагуур, монгор, бао-ань хэлэнд байх бөгөөд төлөөний үгс бие даасан өргөлтөө алдах, гийгүүлэгч, эгшиг авиа сугарах, гээгдэх зэрэг авианы хувьслыг туулан хөгжжээ. Харин хамааны тийн ялгалт төлөөний үгээс үүдэлтэй бүлэг бүтээврийг нөхцөл хэмээн үзэх, эсэх талаар эрдэмтэд харилцан адилгүй саналтай байдаг. Тухайлбал, монгол хэлэнд “биед хамаатуулах нөхцөл” гэдэг боловч зөв бичгийн дүрэмдээ өмнөх үгээс нь салангид бичдэг. Өвөр Монголын эрдэмтэд *минь*, *чинь* хоёрыг “бие заах сул үг” гэдэг, Оросын эрдэмтэд мөн “частица” (сул үг) хэмээн нэрлэдэг. Энэ нь буриад хэл, аялгуунд нэгдүгээр нүүрт (биед) хамаатуулах *-m/-mni/-mнай* [-m/-mni/-mnæ:], *-ни/-най* [-ni/-næ:] хоёр хэлбэртэй бөгөөд орчин цагийн монгол хэл, аялгуунуудын дотор хамгийн богино хэлбэртэй. Доор харьцуулан үзүүлбэ.



Жишээ нь: *Би юун гэхэбийб* [кэхэβi:β] *даа юрэл буянаар холбогдохон хайн хайхан юумэ гээшэ ааб даа. Дари бидэ хоёр иймэ ара үбэртэ алдартай суутай, баян бүдүүн, үнэр үргэн хүнтэй худа ураг болохобди* [bɔlɔχɔβdi] *гээжэ ханаан заяан хоёртоо оруулаашьгүй ябаһан хоёр гээшэбди* [ge:ʃɔβdi].

Ийнхүү хамааны тийн ялгалт биеийн төлөөний үгээс биед хамаатуулах нөхцөл үүсэж хөгжих үйл явц олон монгол хэл, аялгуунд янз бүрийн байдлаар үргэлжилж, одоо ч дуусаагүй байгаа юм. Харин буриад хэлэнд хамгийн системтэйгээр дууссан гэж эрдэмтэн Котвич дүгнэсэн бол “монгол хэлний ойрд, буриад аялгуунд халх аялгуунаас түрүүлж яваа” гэж эрдэмтэн М.Саруул-Эрдэнэ (2002: 47) тэмдэглэсэн байдаг. Буриад хэл, аялгуунд бие заах болон биед хамаатуулах хоёр нөхцөл өөр хоорондоо нягт уялдсан тогтолцоотой, бүтээврийн шинжийг бүрэн олж, хэлний хэмнэлтийн зарчмаар хөгжсөн хэлбэртэй байдгийг дээрх нэгдүгээр биеийн бүтээврүүдээр жишээлэн харж болно.

Өмнөд монгол хэлний баарин аман аялгуунд байдаг ‘дотор’ хэмээх үгээс үүдэлтэй [-t^här/-t^hər/-t^hör/-t^hör] нөхцөл ([tsawsärt^här] — *завсартар* /*завсарт*/ *орох*),

буриад хэлний ‘досоо’ хэмээх язгуураас үүдэлтэй [-sə:] нөхцөл ([gəlsə:] — *гол соо загаһан олон*), цахар, ордос аман аялгуунд байдаг ‘дээр’ гэдэг үгээс үүссэн [-ta:r/-tə:r/-tə:r] нөхцөл ([motən ta:r] — *мудан даар /модон дээр/ суу*), мөн дагуур хэлэнд байдаг [-a:tʰən/-ə:tʰən/-ɔ:tʰən/-e:tʰən] нөхцөл ([kəgə:tʰən] — *гэрээтэн /гэр дотор/*) зэргийг өвөр монгол эрдэмтэд “орон байрын тийн ялгал” (Түмэнжаргал нар, 2009: 397) хэмээн нэрлэжээ. Энэхүү шинэ тийн ялгал үүсэн бүрэлдэх явц нь хэл, аялгуунуудад харилцан адилгүй байгаагаас өмнөд монгол хэлний барга-буриад аялгуунд [-sa:/-sə:/-sə:/-sə:] хэлбэртэй болж, нөхцөл бүтээврийн шинжийг бүрэн олсон байна. Жишээ нь: [ohansa:] — *уһансаа /усан дотор/*, [gəlsə:] — *голсоо /гол дотор/*, [gərsə:] — *гэрсээ /гэр дотор/* гэх мэт.

Дутагдах утга заадаг үйл үгийн *-baᠰu/-beᠰü* нөхцөлийн гарал нь *-ba* (өнгөрсөн цаг) + *ᠰü* (хүч нэмэгдүүлэх сул үг) юм. Энэ бүтээвэр эртний болон дунд үеийн монгол хэлнээс орчин цагийн монгол хэлнүүд хүртэл хөгжихдөө уруулын *b* гийгүүлэгч суларч *w* гийгүүлэгч, [o:/u:] эгшиг болсон, хамжих *ᠰ* гийгүүлэгч суларч хамжин шүргэх [ʃʰ], шүргэх [ʃ] гийгүүлэгч болсон зэрэг хувьслыг туулжээ. Буриад хэл, аялгуунд өмнөх гийгүүлэгч ба эгшиг нь бүр байхгүй болж дан ганц [ʃ] гийгүүлэгч үлдсэн байна. Эндээс тухайн нөхцөлийн үндсэн элемент нь харагдах бөгөөд буриадад хамгийн ихээр хэмнэгдсэн байна. Харьцуулан харуулья:

ӨМХ. **ba+ᠰü* > ЭМХ-ДМХ. Мо. *-baᠰu/-beᠰü* >

→ ОЦМХ. барга-буриад. [-baʃ/-beʃ/-boʃ], өмнөд м.х./цахар/. [-wəʃʰ] >
 халх., ойрад. [-wʃʰ], [-o:ʃʰ/-u:ʃʰ], өмнөд м.х./хорчин/. [-o:ʃ/-u:ʃ] >
 буриад. [-ʃ]

Жишээ нь: *Таные байхгүйи хаа* [bæ:χyüiʃ ha:] *би гэртэтнай хаадгүй ошоход*.

Буриад хэл, аялгуунд нэгдүгээр биед “найдуулан хандаһан түлэб”-ийн *-уужа/-үүжэ* [o:za/-u:zə], *-гуужа/-гүүжэ* [-ko:za/-yu:zə] нөхцөл байдаг. Жишээ нь: *Баярайнгаа тухай байтараа хэлүүжэб* [xəlu:zəβ]. /*А.Шадаев*/. *Бадмын бэри болоогүйдөө бү өөдлүүжэм* [ø:dlu:zəm], *бү жаргуужам* [zəgə:zəm]. *Бадмын нюһан хүбүүндэ ошонхаар, үхөөшэм дээрэ*. /*Х.Намсараев*/. Энэ нөхцөл монгол бичгийн *-туй* *ya* нийлцээс үүсэлтэй (Сэцэнцогт, 1988: 2914). Монгол хэлний халх аялгуунд *-мз* [-mʃ] хэлбэртэй (*дараа өгөмз* — [øγəmʃ]) болсон бол буриад хэл, аялгуунд авианы хувьслын хууль ёсны дагуу хөгжиж, эхний уруулын гийгүүлэгчийн хамжих шинж нь суларч, уруулын эгшиг болсон байна.

Авиа зүйн хувьд буриад хэл, аялгууг сонгодог монгол бичгийн хэлний үе болон бусад монгол хэл, аялгуутай харьцуулбал *ᠰ*>[tʰ]>[s], *ᠰ*>[ʃʰ]>[ʃ], *ʃ*>[tʃ]>[z], *ʃ*>[ʃʃ]>[z], *s*>[h], *q/k*>[χ/x]>[h] гийгүүлэгчүүд өгүүлэх эрхтний хүчдэлийн хувьд суларсан байдаг. Түүний улмаас *-aᠰa/-eᠰe*>[-ha:/-he:/-hə:/-hə:], *ᠰoγu*>хори-бур.[-sə:], барга-бур.[-sa:/-sə:/-sə:], *ᠰini*>[ʃni], *-γsan/-gsen*>[-haŋ/-həŋ/-həŋ], *-γᠰi/-gᠰi*>[-χʃa/-χʃə/-χʃə], *-quiᠰa/-küiᠰe*>барга-бур.[-χi:sa/-xχi:sə/-χi:sə], *-ju/-jü*>[-za/-zə/-zə], *-γsayar/-gseger*>[-ha:r/-he:r/-hə:r/-hə:r], *-basu/-besü*>[-ha:/-he:/-hə:/-hə:], *-baᠰu/-beᠰü*>[-ʃ], *-su/-sü*>[-ho:/-hu:], *-mui ja* > [-o:za/-u:zə], *-γuᠰai/-güjei*>[-ko:za/-yu:zə], *-γaᠰi/-geᠰi*>[-i:ʃ/-i:ʃʰ], барга-бур.[-a:ʃ/-ə:ʃ/-ɔ:ʃ/-ø:ʃ], *-γasai/-gesei*>[-hæ:/-he:/-hæ:] гэх мэтээр

нөхцөл бүтээврүүдийн хэлбэр өөрчлөгдсөн нь мөн л хэлний хэмнэлтийн зарчимтай холбоотой.

2.3. Үгийн сангийн түвшинд

Монгол хэлний утга зохиолын суурь — халх аялгуунд 2-3 үгээр хэлдэг зарим үгийг буриад хэл, аялгуунд нэг үгээр оновчтой илэрхийлсэн тохиолдол цөөн биш байна. Тэдгээр үгээр монгол хэлний утга зохиолын хэлийг баяжуулж болно. Ер нь аливаа хэлний үгийн сан баяжих нэг чухал арга нь нутгийн аялгуунаас суурь аялгуунд үг орох явдал байдаг. Жишээ нь: [sa:dar] — *саадар* (нөгөөдрийн цаад өдөр), [amla:dahan] — *амлаадахан* (ханын боолт), [tʰo:ʃa:ŋ] — барга-буриад. *туушаан* (том аяга), [alkaβʃa] — *алгабша* (хүүхдийн хагархай өмд), [ʃakaβʃa] — *шагабша* (богино оймс), [arβa:dæ:] — *арбаадай* (эвлүүлдэг модон тоглоом), [zomla:dahan] — *зумлаадахан* (могойн арьс), [bɔ:vɔl] — *боогол* (малын хашаа) гэх мэт үг бий.

Халхчууд аав, ээжийнхээ алины нь ч аав, ээжийг ялгалгүй өвөө, эмээ гэдэг бол буриадууд аавынхаа аав, ээжийг [хүүʃаβа] — *хөгшин аав*, [хүүʃizi:] — *хөгшин ээж* гэж; харин ээжийнхээ аав, ээжийг [накасаβа] — *нагац аав*, [накасази:] — *нагац эжий* гэж ялгаж хэлдэг.

[a:raɣ] — *аараг* гэж халх аялгуунд газрын жалга сархиаг, дов толгодыг хэлдэг бол буриад аялгуунд ховор, цөөн зүйлийг хэлдэг хийсвэр утгатай үг. Тэгш тал нутагтай (жалга сархиаг, хад уул ховор) газар нутгийн онцлогтой холбоотой сэтгэлгээнээс энэ үгийн утга ийнхүү хийсвэржин хөгжсөн нь сонирхолтой бөгөөд буриад зоны сэтгэхүйн хийсвэрлэлийг илэрхийлдэг үгсийн нэг жишээ болно.

Дүгнэлт

Ийнхүү буриад хэл, аялгуунд: Нэг талаас, монгол хэлний эртний язгуур шинж хэлний түвшин бүрд хадгалагдан үлдсэн байна. Нөгөө талаас, хэлний хэмнэлтийн жишээ болсон авианууд, тухайн нөхцөлийн үндсэн цөм утгыг илэрхийлдэг ганц авиа болтлоо хураагдсан бүтээврүүд, утга зохиолын хэлний суурь аялгуунд 2-3 үгээр илэрхийлдэг зүйлийг нэг үгээр оновчтой хэлсэн үгс байна. Эрдэмтэн П.Бямбасангийн хэлсэнчлэн “Монгол хэл бол хэлний хөгжлийн үндсэн эрмэлзэл гайхалтай сайн хэрэгжиж, авиа зүй, хэл зүйн байгуулалт, үгийн сан нь жигдрэн хөгжсөн монгол хүн бүрийн нандигнан хамгаалж, бахархаж явбал зохих тэргүүний хөгжилтэй хэл мөн” [5, т. 329] хэмээх үнэлэлтэд буриад хэл, аялгуу чухал байр суурь эзэлнэ. Буриад зоны хэл яриа бол эх монгол хэлнийхээ язгуур шинж болоод хөгжил хандлагыг илтгэгч, арвин баялаг, үнэ цэнтэй нэгэн чухал хэсэг зайлшгүй мөн.

Номзүй

1. Базаррагчаа М. Монгол хэлний үйлийн тийн ялгал. Улаанбаатар, 1999. 147 тал.
2. Базаррагчаа М. Монгол хэлний нэрийн тийн ялгалын нөхцөлийн гарлын тухайд // Монгол хэлний бүтээвэр судлал: эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган. II боть. Улаанбаатар, 2017а. 70–91 тал.
3. Базаррагчаа М. Монгол хэлний өгүүлбэр төгсөхийн учир // Монгол хэлний өгүүлбэр судлал: эрдэм шинжилгээний өгүүллийн чуулган. IV боть. Улаанбаатар, 2017б. 137–154 тал.
4. Бертагаев Т. А. К генезису некоторых падежей в монгольских языках // Краткие сообщения Института народов Азии АН СССР. Вып 83. Монголоведение и тюркология. Москва: Изд-во АН СССР, 1964. С. 41–45.

5. Бямбасан П. Хэлний хэмнэх эрмэлзэл монгол хэлэнд хэрэгжсэн тухай цухас өгүүлэх нь // Монгол хэлний онол, бүтцийн асуудал. Улаанбаатар, 2006.
6. Бямбасан П. Хэлний хэмнэх эрмэлзэл монгол хэлэнд хэрэгжсэн тухай цухас өгүүлэх нь / Монгол хэлний онол, бүтцийн асуудалд // Хэл зохиолын хүрээлэн Монголын алтай судлаачдын холбоо VII. Улаанбаатар, 2006. 323–329 тал.
7. Гантогтох Г. Монгол хэл, аялгуу, үсэг бичгийн судлал. Улаанбаатар, 2018.
8. Дөш М. Монгол Улс дахь буриадчуудын хүн амын тоо // Буриад судлал — XIII. Улаанбаатар, 2025. 100–121 тал.
9. Лувсанжав Чой. Монгол хэлний тийн ялгалын тухай / МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар, 1972. № 41.
10. Рамстедт Г. И. Введение в алтайское языкознание. Москва, 1957. 256 с.
11. Ринчен Б. Монгол бичгийн хэлний зүй, дөтгөөр дэвтэр. Өгүүлбэр зүй. Улаанбаатар, 1967.
12. Ринчен Б. Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн // Монгол хэлний зүйн бичиг (Удиртгал, авиа, үг, өгүүлбэрийн зүй). Улаанбаатар, 2015.
13. Санжаа Ж. Авиа сулрах ёс монгол хэл аялгууны хөгжлийн чухал нэг хандлага мөн // Авиа — авиалбар — их авиалбар (Үгүүлэл, товхимлын эмхэтгэл). Улаанбаатар, 2011. 123–136 тал.
14. Саруул-Эрдэнэ М. Монгол хэлний нөхцөл бүтээврийн үгзүйн түүхэн хувьсал. Улаанбаатар, 2002.
15. Сэнгэ нар (Sengge, Narančimeg). Kōlūn buyir ayimaγ / Kōlūn buyir qota/-un boti. Öbür mongγol-un mongγol kelen-ü nutuγ-un ayalγun-u γaγar-un jiruy-un bayičaγalta-yin material-un čubural. Kōkeqota, 2018.
16. Сеєенцоγту (Сэцэнцогт). Mongγol üges-ün ijayur-un toil. Kōkeqota, 1988.
17. Төмөртогоо Д. Монгол хэлний хөгжлийн түүх, түүний үе шат. Улаанбаатар, 1992. 1–34 тал.
18. Төмөртогоо Д. Монгол хэлний бичигийн дурасхалуудын үгийн бүтэцийн харьцуулсан судалгаа. Улаанбаатар, 2011.
19. Tūmenjirγal nar (Түмэнжаргал нар). Odu üy-e-yin mongγol kele. Kōkeqota, 2009.
20. Цэрмаа Т. Агын буриадын аман аялгууны онцлог // Хэл бичгийн ухааны дэд докторын зэрэг горилж бичсэн ганц сэдэвт зохиол. Улаанбаатар, 2005
21. Poppe N. Introduction to Mongolian Comparative Studies // MSFOu.110. Helsinki, 1955.
22. Ramstedt G. J. Uber die conjugation des Khalkha-mongolischen // MSEOu 21. XV. Helsingfors, 1902.

2026 оной февруалин 23-да статья редакцияда ороо; 2026 оной мартын 4-дэ зүбшөөл гараа; 2026 оной мартын 31-дэ хэблэлдэ ороо.

The Invaluable Role of the Buryat Language and Its Dialects in the Study of Related Mongolic Languages and Their Dialects

Gerelt-Od Batzaya

Doctor of Sciences (Sc.D.), A/Prof.

Institute of Language and Literature

Mongolian Academy of Sciences

54a Zhukov Prospekt, Bayanzurkh District, 13375 Ulaanbaatar, Mongolia

batzaya.g@mas.ac.mn

Abstract. Currently, there are approximately 661,000 Buryats living in Russia, around 101,980 in Mongolia, and over 70,000 in China, totaling roughly 833,000 people

worldwide. In Russia, the Buryat language has developed into an independent form, whereas in Mongolia, it is considered a language. Linguistic analysis reveals that the Buryat language and its dialects contain features that have preserved early forms of the Mongolic language to the present day; conversely, they also possess evolved elements that indicate the direction of the Mongolic language's evolution. Therefore, the Buryat language and its dialects hold significant linguistic value and can play an invaluable role in the study of Mongolian dialects and related languages. This article provides examples of texts in the literary Buryat language written according to Buryat orthographic rules, texts in Buryat dialects of the Mongolian language written using Mongolian orthographic rules, and examples of word pronunciation recorded using the International Phonetic Alphabet (IPA). However, in the section comparing the chronological order of Ancient Early, and Middle Mongolian texts, the examples are provided in written form.

Keywords: Buryat language, dialect, ancient forms, development trends, value.

For citation

Gerelt-Od Batzaya. The Invaluable Role of the Buryat Languages and Its Dialects in the Study of Related Mongolic Languages and Their Dialects. *Buryat Language and Literature in School*. 2026; 1: 25–35 (In Mong.)

The article was submitted 23.02.2026; approved after reviewing 04.03.2026; accepted for publication 31.03.2026.